

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.3.4 дэх заалт нэмсүгэй:

“27.3.4.Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.5, 12.6-д заасан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд нийцээгүй.”

2 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.3.энэ хууль болон Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.5, 12.6-д заасан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний шаардлагад нийцэж байгаа эсэх.”

3 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 12 зүйлийн 12.1.1 дэх заалтын “эрх бүхий байгууллагаас” гэсний өмнө “Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.5, 12.6-д заасан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө болон” гэж нэмсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “Хот байгуулалтын тухай хуулийн” гэсний дараа “12 дугаар зүйлийн 12.4, 12.5, 12.6-д заасан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний шаардлагын” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалтын “төлөвлөгөөг” гэсний дараа “холбогдох хуульд заасан шаардлагад нийцсэн эсэхийг хянаж,” гэж, 30 дугаар зүйлийн 30.1.12 дахь даалтын “хэрэгжүүлэх” гэсний дараа “, тайлагнах” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хууль болон уг хуулийг дагалдан батлагдсан Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд заасан тусгай шаардлагад нийцүүлэн боловсруулж 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө батална.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу баталсан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд заасан тусгай шаардлагад барилгын ажлын зөвшөөрлийг нийцүүлнэ.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу баталсан хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд заасан тусгай шаардлагад нийцүүлээгүй барилгын ажлын зөвшөөрлийг хүчингүй болгоно.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Хот байгуулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг